



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А7/12

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 76 дугаар зүйл, 78 дугаар зүйлийн 78.2, 78.3, “Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлах тухай” Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2009 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 305 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Гадаад харилцааны яам, Дипломат төлөөлөгчийн газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтээр амрах баярын өдрүүдэд “Хариуцлагатай эргүүл, жижүүр томилон ажиллуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг яамны нийт газар, нэгж, ДТГ-ууд болон Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газрын удирдлагад тус тус танилцуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэнд үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Хариуцлагатай жижүүрийн ажлыг журамлах тухай” Гадаад хэргийн сайдын 1995 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 141 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Д.ЦОГТБААТАР

080049

Гадаад харилцааны сайдын
2019 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн
А/12 дугаар тушаалын хавсралт



ХАРИУЦЛАГАТАЙ ЭРГҮҮЛ, ЖИЖҮҮР ТОМИЛОН АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нийтээр амрах баярын өдрүүдэд ГХЯ (цаашид “яам” гэх) болон хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газрууд (цаашид “ДТГ-ууд” гэх)-дад хариуцлагатай эргүүл, жижүүр томилон ажиллуулахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 ДТГ-ын тэргүүн суугаа орныхоо онцлог, нөхцөл байдлыг харгалзсан “Хариуцлагатай эргүүл, жижүүр томилон ажиллуулах журам”-ыг батлан хэрэгжүүлж болно.

Хоёр. Хариуцлагатай эргүүл, жижүүр томилох

2.1 Нийтээр амрах баярын өдрүүд буюу Шинэ жил (1 дүгээр сарын 1), Цагаан сар (билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1, 2, 3), Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр (3 дугаар сарын 8), Хүүхдийн баяр (6 дугаар сарын 1), Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр (7 дугаар сарын 11, 12, 13, 14, 15), Их Эзэн Чингис хааны өдөр (Их Эзэн Чингис хаан мэндэлсэн билгийн тооллын өвлийн тэргүүн сарын шинийн 1), Бүгд Найрамдах Улс тунхагласан өдөр (11 дүгээр сарын 26), Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр (12 дугаар сарын 29)-ийн амралтын өдрүүдэд яам, ДТГ-уудад ажиллах хариуцлагатай эргүүл, жижүүрийг яамны Төрийн нарийн бичгийн даргын болон ДТГ-уудын тэргүүний тушаалаар тус тус томилно.

2.2 Хариуцлагатай эргүүлийн үүргийг яамны газрын дэд захирал болон ДТГ-уудын ахлах албан тушаалтан, хариуцлагатай жижүүрийн үүргийг ГХЯ-ны болон ДТГ-уудын дипломат ажилтан, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний ажилтнууд тус тус гүйцэтгэнэ.

2.3 Төрийн захиргааны удирдлагын газар (ТЗУГ) энэхүү журмын 2.1-д заасан нийтээр амрах баярын өдрүүдэд яаманд хариуцлагатай эргүүл, жижүүрээр ажиллахаар томилогдсон ажилтнуудын мэдээллийг ДТГ-уудад хүргүүлэх бөгөөд ДТГ-ууд мөн энэ тухай мэдээллээ ТЗУГ-т ирүүлнэ.

Гурав. Хариуцлагатай эргүүл, жижүүрийн эрх, үүрэг

3.1 ГХЯ, ДТГ-уудын хариуцлагатай жижүүрийн үүрэг:

3.1.1 яам, ДТГ-уудад хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэж буй ажилтнууд хоорондоо байнга холбоотой ажиллаж, улс орны дотоодод болон суугаа оронд болж буй онцлог үйл явдлууд, үүссэн нөхцөл байдлын талаар харилцан мэдээлэл солилцоно.

3.1.2 яам, ДТГ-уудын аюулгүй байдлыг хангах, болзошгүй аюул, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллана.

3.1.3 гадаад харилцааны салбарын хэмжээнд шуурхай шийдвэрлэх шаардлагатай аливаа тулгамдсан асуудлыг яам, ДТГ-уудын хариуцлагатай эргүүлд цаг алдалгүй танилцуулж, чиглэл авч ажиллана.

3.2 ГХЯ, ДТГ-уудын хариуцлагатай эргүүлийн үүрэг:

3.2.1. яам, ДТГ-уудад хариуцлагатай эргүүлийн үүрэг гүйцэтгэж буй албан тушаалтнууд хоорондоо байнга холбоотой ажиллаж, улс орны дотоодод болон суугаа оронд болж буй онцлог үйл явдлууд, үүссэн нөхцөл байдлын талаар харилцан мэдээлэл солилцоно.

3.2.2 яам, ДТГ-уудын хариуцлагатай жижүүрүүдийг шуурхай удирдлагаар хангаж, тэдний үүргийн биелэлтэд хяналт тавина.

3.2.3 шаардлагатай тохиолдолд улс орны дотоодод болон суугаа оронд, түүнчлэн олон улсад өрнөж буй онцлог үйл явдлууд, үүссэн нөхцөл байдлын талаар яамны болон ТЗУГ-ын удирдлагыг мэдээллээр шуурхай хангаж, чиглэл авч ажиллана.

3.2.4 гадаад харилцааны салбарын хэмжээнд шуурхай шийдвэрлэх шаардлагатай аливаа тулгамдсан асуудлыг яамны удирдлага болон ТЗУГ-ын захиралд шуурхай танилцуулж, чиглэл авч ажиллана.

3.3 ТЗУГ хариуцлагатай эргүүл, жижүүрт үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай мэдээлэл (хилийн чанад дахь ДТГ-уудын хариуцлагатай эргүүл, жижүүртэй харилцах утасны дугаар, цахим хаяг, Улаанбаатар дахь гадаадын ДТГ-уудын утасны дугаар, онцгой байдлын болон цагдаагийн байгууллага, гал команд, цагдаа, эмнэлгийн түргэн тусламж зэрэг байгууллагын холбогдох албан тушаалтны утасны дугаар, галын хор ажиллуулах заавар г.м.) болон өрөө, техник хэрэгсэл, автомашинаар хангах арга хэмжээ авна.

3.4 ДТГ-ууд хариуцлагатай эргүүл, жижүүр үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай мэдээлэл (ГХЯ-ны хариуцлагатай эргүүл, жижүүртэй харилцах утасны дугаар, цахим хаяг, гадаадын ДТГ-т үйлчилдэг суугаа орны онцгой байдлын болон цагдаагийн байгууллага, гал команд, цагдаа, эмнэлгийн түргэн тусламж зэрэг байгууллагын утасны дугаар, галын хор ажиллуулах заавар г.м.) болон өрөө, техник хэрэгсэл, автомашинаар хангах арга хэмжээ авна.

3.5 Яамны хариуцлагатай жижүүрээр ажилласан ажилтнууд хамтран нэгдсэн Илтгэх хуудас бичих бөгөөд хариуцлагатай эргүүл Илтгэх хуудсанд гарын үсэг зурж, баталгаажуулан ТЗУГ-ын захиралд танилцуулна.

3.6 ДТГ-ууын хариуцлагатай жижүүрээр ажилласан ажилтан Илтгэх хуудас бичих бөгөөд хариуцлагатай эргүүл Илтгэх хуудсанд гарын үсэг зурж баталгаажуулан ДТГ-ын тэргүүнд танилцуулна. ДТГ-ын тэргүүн хариуцлагатай эргүүл, жижүүр томилж ажиллуулсан дүнг ТЗУГ-т мэдээлнэ.

3.7 ТЗУГ-ын захирал яам, ДТГ-уудад хариуцлагатай эргүүл, жижүүр томилж ажиллуулсан тухай дүнг нэгтгэн яамны удирдлагад танилцуулна.

3.8 Хариуцлагатай эргүүл, жижүүрээр ажилласан ажилтан, албан тушаалтныг Хөдөлмөрийн тухай хуулийн 78.3-т заасны дагуу ажлын өдөр нөхөн амруулах, эсхүл нөхөн амралтыг ээлжийн амралттай нь хамтатган олгоно.

Дөрөв. Хариуцлага хүлээлгэх

4.1 Энэхүү журмыг зөрчсөн болон хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хангалтгүй биелүүлсэн ажилтан, албан тушаалтанд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлагыг зохих журмын дагуу хүлээлгэнэ.
